



ХЭНТИЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2021 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 21.

Чингис хот

Санал уламжлах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.6, 3.8, 3.8.2-т заасныг тус тус үндэслэн аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн саналыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2021 оны гуравдугаар хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Цэнхэрмандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төрийн захиргааны албан хаагчдын төрийн албанд ажилласан буюу тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, 2020 оны үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг харгалзан үзэж ахлах түшмэлийн ангиллын 1, дэс түшмэлийн ангиллын 7, туслах түшмэлийн ангиллын 6 албан хаагчдад хавсралтад дурдсанаар зэрэг дэв олгуулах саналыг аймгийн Засаг дарга /Ц.Идэрбат/-д уламжилсугай.

2. Энэхүү тогтоолыг аймгийн Засаг даргад өргөн мэдүүлж зэрэг дэв олгуулах асуудлыг шийдвэрлүүлж, гарсан шийдвэрийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Цэнхэрмандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга /Ж.Саруултөгс/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР